



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 06

Чингис хот

Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын нарийн бичгийн даргын
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 2019 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, 2020 оны 141 дүгээр “Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /106/ авсан Бумбаагийн Нямдэлгэрийг Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Нямдэлгэрийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Аюурзана/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Биндэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

